



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 29 өдөр

Дугаар А/176

Ховд

Зарим байгууллага, аж ахуйн нэгжүүдийн үйл-
ажиллагааг түр хязгаарлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ын “а”, “л”, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.8, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4 дэх заалт, аймгийн Онцгой комиссын хуралдааны 2021 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн 24 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн нутаг дэвсгэрт Ковид-19-ийн тохиолдол батлагдсантай холбогдуулан аймгийн төв, сумдын Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, бар, ресторан, караоке, зах, худалдааны төвүүдийн үйл ажиллагааг 2021 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн 22.00 цагаас 04 дүгээр сарын 02-ны өдрийн 00.00 цаг хүртэл түр хязгаарласугай .

2.Аймгийн нутаг дэвсгэрт хязгаарлалт тогтоосонтой холбогдуулан Төрийн байгууллагуудын албан хаагчдын 15 хүртэлх хувийг ажиллуулан бусад албан хаагчдыг гэрээсээ ажиллах боломжоор хангах зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг байгууллагын удирдлагуудад үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж, олон нийтэд сурталчилж ажиллахыг Баруун бүсийн төв-Ховд аймгийн Онцгой байдлын газар /хурандаа Б.Алтанбадралт/, сумдын Засаг дарга нар, Цагдаагийн газар /цагдаагийн хурандаа Э.Даваасүрэн/, Мэргэжлийн хяналтын газар /П.Эрдэнэчулуун/, аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагуудад үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Zax A/176 Ch
02 1936